

  
МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

“Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс”-ын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дашням овогтой Золжаргалыг АНУ-ын Оклахома Сити Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Амаржаргал овогтой Хүрэлбатыг Малайзи улсын Multimedia Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр, Дэмбэрэлдаш овогтой Баярсайханыг АНУ-ын Индианагийн Их сургуулийн магистрантурт төрийн захиргааны чиглэлээр, Онон овогтой Мичидийг АНУ-ын Сан-Франциско хотын Уран зургийн академи коллежийн магистрантурт 2 жилийн хугацаагаар, Очирхүү овогтой Ариунзулыг АНУ-ын Вирджинийн Олон улсын Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2002-2003 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Япон улсын Хирошима Их сургуулийн магистрантурт суралцаж буй Булгаа овогтой Ганбатын суралцах хугацааг хагас жилээр сунгасугай.

3. АНУ-ын Висконсин-Милваукигийн Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр суралцаж буй Нямаа овогтой Байгалмаагийн хагас жилийн сургалтын төлбөр, ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Алс дорнодын салбарын харьяа Владивосток хотын Биологи хөрсний хүрээлэнгийн докторантурт суралцаж буй Янсанжав овогтой Адъяа, ОХУ-ын Эрхүү хотын Эдийн засгийн академийн докторантурт суралцаж буй Сүхрагчаа овогтой Нямзагд, Казахстаны Алматы хотын Эрүүл ахуй тархвар судлалын эрдэм шинжилгээний төвийн

докторантурт суралцаж буй Чунт овогтой Эрхэмцэгэг нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг тус тус зээлээр олгосугай.

4. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



А.ЦАНЖИД